

НИЙСЛЭЛИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН 2025 ОНЫ ТАЙЛАН

2026 оны 01 дүгээр сарын 14

Улаанбаатар хот

НЭГ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ЗОРИЛГО

Хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго нь Хот байгуулалт, хотын стандартын газрын 2025 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, тухайн онд тавьсан зорилт, хүрэх үр дүнг үнэлэх, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг сайжруулахад зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв бодит мэдээллээр хангах, дараагийн шатны төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

ХОЁР. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Барилга, хот байгуулалтын салбарт хамаарах бодлогын баримт бичиг, холбогдох эрх зүйн акт болон Засгийн газар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын болон Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улс, Нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, байгууллагын ил тод байдал, төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлтэд Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ыг баримтлан хяналт шинжилгээ хийж, санал дүгнэлт өгч ажиллаа.

ГУРАВ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ҮР ДҮН

Хяналт шинжилгээ, үнэлгээг Улс, нийслэлээс хэрэгжүүлж буй урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрт Хот байгуулалт, хотын стандартын газрын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт болон бусад мэдээ, тайланд тулгуурлан Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу 3 багц, 14 үзүүлэлтээр дүгнэв.

Төлөвлөсөн арга хэмжээ бүрийн биелэлтийн 2025 онд хүрсэн бодит үр дүнг хүрвэл зохих түвшинтэй харьцуулан хувиар тодорхойлж үнэлгээг гаргахад байгууллагын ерөнхий үнэлгээ **89,2** хувь буюу **"Бүрэн хангалттай"** дүгнэлттэй байна.

Хүснэгт 1. Хот байгуулалт, хотын стандартын газрын
2025 оны үйл ажиллагааны үнэлгээний дүн:

№	Үзүүлэлт		Хувь
1	2	3	4
1	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	90,0
		2. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	63,6
		3. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө	100
		4. Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	90,9
		5. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	62,5
		6. Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө	80,1

1	2	3	4
		7. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэр	96,8
		Хэсгийн дундаж хувь:	83,4
2	Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө	99,3
		2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр	97,8
		3. Газрын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүрэг	100
		4. Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт	99,0
		Хэсгийн дундаж хувь:	99,0
3	Байгууллагын ил тод, нээлттэй байдлын үнэлгээ	1. Газрын мэдээллийн ил тод, нээлттэй байдал	63,1
		2. Төсөв, санхүүгийн ил тод байдал, шилэн дансны хөтлөлт	92,4
		3. Хэрэглэгчийн үнэлгээ	100
		Хэсгийн дундаж хувь:	85,1
		Ерөнхий үнэлгээ:	89,2

3.1. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ

3.1.1. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт.


Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тус байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд 2025 онд 3 зорилт, 4 арга хэмжээ тусгагдсан бөгөөд хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, **90,0** хувьтай буюу **"Үр дүн гарсан"** дүгнэлттэй байна.

Хэрэгжилтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 01/1371 дугаартай албан бичгээр хүргүүлж, файлыг байгууллагын дотоод сүлжээнд Z:\0.KHOT BAIGUULALT, KHOTIIN STANDARTIIN GAZAR\4. BIELELT\6. 2025\1. BODLOGIIN BARIMT BICHIG\2. MU-IIN UNDSSEN CHIGLEL байршуулав.

3.1.2. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 218 дүгээр тогтоолоор баталсан Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тус байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан 20 зорилт, 31 арга хэмжээний хэрэгжилтийг хангуулж ажилласан байна. Хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, хэрэгжилтийн түвшин өссөн дүнгээр жилийн эцсийн байдлаар **63,6** хувьтай буюу **"Үр дүн хүлээгдэж байгаа"** дүгнэлттэй байна. Үүнд:

Зураг 1. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт:



Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 01/1371 дугаартай албан бичгээр хүргүүлж, файлыг байгууллагын дотоод сүлжээнд Z:\0.KHOT BAIGUULALT, KHOTIIN STANDARTIIN GAZAR\4. BIELELT\6. 2025\1. BODLOGIIN BARIMT BICHIG\3. ZGUAN байршуулав.

3.1.3. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тус байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан 2 арга хэмжээний хэрэгжилтийг хангуулж ажилласан байна. Хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийн түвшин **100** хувьтай, **“Үр дүн гарсан”** дүгнэлттэй байна.

Төлөвлөгөөний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 01/1371 дугаартай албан бичгээр хүргүүлж, файлыг байгууллагын дотоод сүлжээнд Z:\0.KHOT BAIGUULALT, KHOTIIN STANDARTIIN GAZAR\4. BIELELT\6. 2025\1. BODLOGIIN BARIMT BICHIG\4. MU-IIN HUGJLIIN 2025 ONI TULUVUGUU байршуулав.

3.1.4. Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/09 дүгээр тогтоолоор батлагдсан Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд Газрын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан 50 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг хангуулж ажилласан байна. Хяналт шинжилгээ, үнэлгээ хийж арга хэмжээний хэрэгжилтийн дундаж **90,9** хувьтай буюу **“Үр дүн гарсан”** дүгнэлттэй байна.

Хэрэгжилтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Дэд бүтэц, хөгжлийн бодлогын хэлтэст 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 01/1369 дугаартай албан бичгээр болон munkhsaihan.b@ulaanbaatar.mn цахим шуудангаар хүргүүлж, файлыг байгууллагын дотоод сүлжээнд Z:\0.KHOT BAIGUULALT, KHOTIIN STANDARTIIN GAZAR\4. BIELELT\6. 2025\4. NIISLELIIN BARIMT BICHIG\1. NIISLELIIG 2021-2025 OND HUGJUULEH UNDSSEN CHIGLEL байршуулав.

3.1.5. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт.

Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1480 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тус байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан нийт 83 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж **62.5** хувьтай буюу **“Үр дүн хүлээгдэж байгаа”** (39 арга хэмжээ) дүгнэлттэй байна.

Хэрэгжилтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн Бодлого, төлөвлөлтийн газарт 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 01/1370 дугаартай албан бичгээр болон munkhsaihan.b@ulaanbaatar.mn цахим шуудангаар хүргүүлж, файлыг байгууллагын дотоод сүлжээнд Z:\0.KHOT BAIGUULALT, KHOTIIN STANDARTIIN GAZAR\4. BIELELT\6. 2025\4. NIISLELIIN BARIMT BICHIG\2. NIISLELIIN ZASAG DARGIIN 2024-2028 ONII UIL AJILLAGAANII HUTULBUR байршуулав.

3.1.6. Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тус байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан 37 арга хэмжээ, 35 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг хангуулж ажилласан байна. Хяналт шинжилгээ, үнэлгээ хийж хэрэгжилтийн түвшин **80,1** хувьтай буюу **“Үр дүнгүй”** дүгнэлттэй байна.

Төлөвлөгөөний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Дэд бүтэц, хөгжлийн бодлогын хэлтэст 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 01/1369 дугаартай албан бичгээр болон munkhsaihan.b@ulaanbaatar.mn цахим шуудангаар хүргүүлэв, файлыг Газрын дотоод сүлжээнд Z:\0.KHOT BAIGUULALT, KHOTIIN STANDARTIIN GAZAR\4. BIELELT\6. 2025\4. NIISLELIIN BARIMT BICHIG\3. NIISLELIIN 2025 ONII HUGJLIIN TULUVLUGUU байршуулав.


3.1.7. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт.

2025 оны жилийн эцсийн байдлаар тус байгууллагын үндсэн чиг үүрэгт хамааралтай Монгол Улсын хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ-ын тогтоол, УИХ-ын Байнгын хорооны тогтоол, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж, Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавар нийлсэн нийт 29 хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 38 заалтыг хяналтад авч, хяналт шинжилгээ, үнэлгээ хийв.

Хүснэгт 2. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн дэлгэрэнгүй дүн:

Үзүүлэлт		Бүгд	Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрүүд								
			Монгол Улсын Хууль	Ерөнхийлөгчийн зарлиг	Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн Зөвлөмж	УАБ-ын Зөвлөлийн хуралдааны тэмдэглэл	Улсын Их Хурлын тогтоол	Улсын Их Хурлын Байнгын	Засгийн газрын тогтоол	Засгийн газрын албан даалгавар	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл
1		2	3	4	5	6	7	8	9	10	11
Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо		29	4	-	1	-	3	-	7	3	11
Хяналтад авсан нийт заалтын тоо		38	6	-	2	-	7	-	9	3	11
Үүнээс	Хэрэгжсэн	30	5		1		6		8	2	8
	Хэрэгжээгүй	-									
	Хугацаа болоогүй	1								1	
	Хяналтаас хасах	7	1		1		1		1		3
Биелэлтийн дүн (хувь)		96.8%	100%	-	100%	-	94.2%	-	98.1%	90.0%	96.8%

Зураг 2. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ:



Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийхэд нийт 29 хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 38 заалтын хэрэгжилтийн дундаж **96,8** хувьтай буюу байна. Үүнд:

- Хэрэгжсэн буюу 85%-с дээш хэрэгжилттэй 30 заалт,
- Хэрэгжээгүй буюу 0-84 хувийн хэрэгжилттэй заалт байхгүй,
- Хугацаа болоогүй 1 заалт,
- Чиг үүрэгт хамааралгүй буюу Хяналтаас хасах саналтай 7 заалт байна.

Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтийг 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний газарт хүргүүлж, файлыг байгууллагын дотоод сүлжээнд Z:\0.KHOT BAIGUULALT, KHOTIIN STANDARTIIN GAZAR\4. BIELELT\6. 2025\2. HUULI TOGTOOMJ, TOGTOOL SHIIDBER байршуулав.

3.2. Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ

3.2.1. Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт.

Төсвийн Ерөнхийлөн захирагч буюу Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай тус газрын удирдлага 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 01/47 дугаартай "Хариуцлагын гэрээ" байгуулан, гэрээний хавсралтаар Хот байгуулалт, хотын стандартын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулсан.

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар **БҮРЭН ХАНГАЛТТАЙ** буюу **99,3%**-иар үнэлэгдэж байна. Үүнд: Нийт 158 арга хэмжээнээс бүрэн хангалттай (85%-иас дээш) 153 арга хэмжээ, Үнэлэх боломжгүй 5 арга хэмжээ байна.

Зураг 3. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 158 ажил, арга хэмжээний хэрэгжилтийн хувь:



Гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтэд хяналт шинжилгээ хийж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн Бодлого, төлөвлөлтийн газарт 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 01/698 дугаартай албан бичгээр, бүтэн жилийн биелэлтэд хяналт шинжилгээ хийж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 01/1385 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлэн ажиллав. Файлыг байгууллагын дотоод сүлжээнд

Z:\0.KHOT BAIGUULALT, KHOTIIN STANDARTIIN GAZAR\2. GUITSETGELIIN TULUVLUGUU@BUSAD TULUVLUGUU\6. 2025\2. Guitsetgeliin tuluvluguunii bielett байршуулав.

3.2.2.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт.

Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын 3 дугаар хавсралтаар хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллуулах, хөгжүүлэх, идэвхжүүлэх, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах талаар байгууллагын зүгээс хэрэгжүүлэх үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг баталсан.

Үүний дагуу хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах 2 зорилт, 9 үйл ажиллагааны биелэлтийг 24 шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлсэн.

Хүснэгт 3. Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт:

№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлтийн тоо	Хэрэгжилт (Хувиар)
1	2	3	4
1. Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх			
1	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан (дотоод сургалт)	3	100
2	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан (гадаад сургалт)	3	100
3	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал	1	100
4	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	3	85
2. Нийгмийн баталгааг хангах хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ			
1	Улирлын урамшуулал олгосон байдал	4	100
2	Нөхөх төлбөрт олгосон зардал, нийт:	-	-
3	Бусад нөхөх төлбөрт олгосон зардал, нийт:	-	-
4	Төрийн албан хаагчид олгосон тусламж, нийт:	2	100
5	Төрийн албан хаагчийн нийтлэг баталгаанд зарцуулсан зардал, нийт:	4	100
Нийт		9	97.8

Хөтөлбөрийн биелэлтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн хэлтэст 2025 оны 01/1482 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

3.2.3.Газрын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийн хэрэгжилт.

Нийслэлийн Засаг даргын 2024 оны "Дүрэм шинэчлэн батлах тухай" А/478 дугаар захирамжаар батлагдсан Байгууллагын дүрмийн 4.1-д үндсэн 18 чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгагдсан бөгөөд 2025 оны байдлаар **100** хувьтай буюу **"Үр дүн гарсан"** дүгнэлттэй байна.

3.2.4. Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт.

Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/111 дүгээр захирамжаар батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн “eDoc” систем ашиглах журам” болон Газрын даргын 2021 оны А/22 дугаар тушаалаар батлагдсан газрын “Албан хэрэг хөтлөлтийн журам”-ыг мөрдлөг болгон ажиллаж байна.

2025 онд байгууллагын хэмжээнд ААН, байгууллагаас нийт 4520 албан бичиг ирж, 2642 албан бичиг явсан байна. Үүнээс:

- 4442 буюу 9863 хувийн шийдвэрлэж,
- 78 буюу 1.7 хувийг нь судалж байна.
- Шийдвэрлэлтийн дундаж хугацаа **6 хоног** байна.

Албан бичгийн хандалтыг болон зөрчлийг өмнөх онтой харьцуулбал:

- Албан бичиг 367 буюу 8.1 хувиар өссөн,
- Зөрчил 51 буюу 74 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

2025 онд иргэдээс нийт 2025 онд нийт 1260 өргөдөл, гомдол ирсэн. Үүнээс:


- 1252 буюу 99.4 хувийг нь шийдвэрлэж,
- 8 буюу 0.6 хувийг нь судалж байна.
- Шийдвэрлэлтийн дундаж хугацаа **8 хоногтой** байна.

Дээрх 1260 өргөдлийн 51.4 хувь нь хүсэлт, 46.9 хувь нь гомдол, 1.7 хувь нь санал эзэлж байна.

Өргөдлийн хандалтыг болон зөрчлийг өмнөх онтой харьцуулбал:

- Өргөдөл 869-өөр буюу 40.8 хувиар буурсан,
- Зөрчил 38-аар буюу 82.6 хувиар буурсан сайн үзүүлэлттэй байна.

Зураг 4. Өргөдөл, гомдлын хандалтыг өмнөх онуудын мөн үетэй харьцуулбал:



3.3. Байгууллагын ил тод, нээлттэй байдлын үнэлгээ

3.3.1. Газрын мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилт.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу байгууллагын цахим хуудсан дахь мэдээллийг 2024 онд тогтмол хариуцан шинэчлэн ажиллах алба, хэлтсүүдийг Газрын даргаар батлуулж, Газрын цахим хуудас дахь мэдээ, мэдээллийг тогтмол тухай бүр шинэчлэх, ойлгомжтой байдлаар байршуулах зарчмаар мэдээллийн сангийн тасралтгүй үйл ажиллагааг хөтлөн явуулж байна.

“Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийг тайлагнах хүснэгт”-ийн дагуу байгууллагын хамаарал бүхий 42 төрлийн мэдээллийн ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт 2025 оны байдлаар **63,1** хувь буюу “Хангалтгүй” хэрэгжилттэй байна.

Зураг 5. Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт:



Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах үүднээс байгууллагын үйл ажиллагааны тайлан, мэдээ, барилгын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл, хууль, эрх зүй болон дотоод дүрэм, журам, албан бичгийн шийдвэрлэлт, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт зэрэг мэдээллийг байгууллагын <https://uds.ub.gov.mn/> цахим хуудсанд байршуулан ажиллаж байна.

Нийслэлийн нутаг дэвсгэрт Хот төлөвлөлтийн асуудал хэлэлцэх Мэргэжлийн зөвлөлийн хурлыг иргэд, олон нийтэд нээлттэй болгож, байгууллагын цахим хуудас болон YouTube хуудсаар шууд (Live) дамжуулан хүргэж, хурлын жагсаалт, санал, дүгнэлтийг байршуулсан.

3.3.2. Төсөв, санхүүгийн ил тод байдал, шилэн дансны хөтлөлт.

Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах үүднээс байгууллагын <https://uds.ub.gov.mn/> цахим хуудас болон <https://shilendans.gov.mn/> цахим хуудсанд төсвийн гүйцэтгэл, хөрөнгө оруулалт болон бусад төсөв, санхүүгийн мэдээллийг тогтмол баяжуулан ажилласан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, www.shilendans.gov.mn цахим системд байгууллагын жилийн төсөв, төсвийн гүйцэтгэл, төсвийн хэмнэлт, аудитын зөвлөмжийн биелэлт, санхүүгийн тайланг тогтоосон хугацаанд тайлагнаж нийт 171 мэдээлэл оруулахаас 2025 оны 12 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар:

- Хугацаандаа мэдээлсэн - 158,
- Хугацаа хоцорч мэдээлсэн - 2,
- Мэдээлээгүй буюу хугацаа болоогүй - 11,

Хэрэгжилтийн хувь 2025 оны 12 дүгээр сарын 26-ны өдрийн байдлаар 92,4%-тай байна. 4-р улирлын шилэн дансны тайланг илгээхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Шилэн дансны 2025 оны нэгтгэл тайлан илгээх хуулийн хугацаа одоогийн үүсээгүй байна.

3.3.3. Хэрэглэгчийн үнэлгээ.

“Хэрэглэгчийн үнэлгээ хийх судалгааны баг” нь 2025 онд нийт 6 арга хэмжээ зохион байгуулахаар ажлын төлөвлөгөө боловсруулж, Газрын даргаар 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр батлуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Тус төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд “Чанарын баг”-тай хамтран иргэдээс авах “Сэтгэл ханамжийн судалгаа”-г 9 төрлийн асуумжаар 32 хариултаас сонгох, 1 асуумжид нөхөж бичих боломжтойгоор бэлтгэн боловсруулав.

Судалгааны багийн 2025 оны ажлын төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэх ажлын хүрээнд 2025 оны Гуравдугаар улирлын байдлаар судалгааны баг нийт 5 удаа хуралдсан. 2025 оны Гуравдугаар улирлын байдлаар газраас үзүүлж буй 9 төрлийн 37 нэр төрлийн үйлчилгээ авахаар Хан-Уул дүүргийн Яармаг дахь нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагуудын цогцолбор “Б” байрны 1 давхар дахь “Нэг цонхны үйлчилгээ”-ээр хандсан иргэд, аж ахуйн нэгжээс тандалт судалгаа авч ажилласан.

Мөн Төрийн албаны зөвлөлийн 30 жилийн ой, “Шинэтгэлээр түүчээлсэн салбар зөвлөл” аяныг зохион байгуулах ажлын хүрээнд Газрын үйл ажиллагааг сурталчлах, газраас үзүүлж буй үйлчилгээний талаар иргэн, хуулийн этгээдэд зөвлөгөө мэдээлэл өгөх “Бид иргэдээ сонсож шийднэ” уулзалтын хуваарийг Захиргаа, удирдлагын хэлтсийн даргаар батлуулан, 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөс 04 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэл 7 албан хаагч, үйлчилгээний ажилтантай хамтран зөвлөгөө мэдээлэл өгч ажиллав. Нийт 65 иргэн, хуулийн этгээдэд зөвлөгөө мэдээлэл өгч, сэтгэл ханамжийн судалгаа авсан.

ДӨРӨВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Улс, нийслэлээс хэрэгжүүлж буй бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрт Хот байгуулалт, хөгжлийн газрын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт болон бусад мэдээ, тайланд тулгуурлан Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу 3 багц, 14 үзүүлэлтээр хяналт шинжилгээ, үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэв.

Төлөвлөсөн арга хэмжээ бүрийн биелэлтийн 2025 онд хүрсэн бодит үр дүнг хүрвэл зохих түвшинтэй харьцуулан хувиар тодорхойлж үнэлгээг гаргахад Байгууллагын ерөнхий үнэлгээ **89,2** хувь буюу “**Бүрэн хангалттай**” дүгнэлттэй байна.

4.1. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ.

Бодлогын баримт бичгийн 7 шалгуур үзүүлэлтийн хэсгийн дундаж **83,4** хувь буюу “**Үр дүн хүлээгдэж байгаа**” үзүүлэлттэй үнэлэгдсэн.

- Тодорхой шалтгааны улмаас хэрэгжилт удаашралтай заалтуудын шалтгаан нөхцөлийг тодорхойлж, цаашид авах арга хэмжээний талаарх саналыг хэлэлцэн шийдвэрлэж байх,
- Бодлогын баримт бичигт тусгагдсан байгууллагад хамаарал бүхий ажлыг ямар нэгэн чиглэл хүлээлгүй санаачилгатай хийж, хэрэгжүүлэн тайлагнах нь зүйтэй. Мөн алба, хэлтсийн дарга нар хүргүүлж буй тайлантай бүрэн танилцсан байхыг хэвшил болгох,
- Төлөвлөгөөний хүрсэн түвшин, хэрэгжилтийг товч тодорхой, шалгуур үзүүлэлтийн дагуу 2000 тэмдэгтэд багтаан, тоо, хувь, нотлох баримтын хамт тайлагнаж хэвших,
- Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн заалт тус бүрт хяналтын карт хөтлөн холбогдох алба, хэлтсийн даргад хүлээлгэн өгч, хяналтад бүрэн авч, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр нэгтгэн тайлагнах шаардлагатай байна.

4.2. Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ.

Байгууллагын чиг үүргийн 4 шалгуур үзүүлэлтийн хэсгийн дундаж **99,0** хувь буюу “**Бүрэн хангалттай**” үзүүлэлттэй үнэлэгдсэн.

- Алба, хэлтсүүд жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа “Нийслэлийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Нийслэлийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөө болон Нийслэлийн 2024-2028 оны Стратеги төлөвлөгөөтэй нягт уялдуулж төлөвлөх, шалгуур үзүүлэлтийг тодорхойлохдоо анхаарах;
- Тайланг бодитой, товч тодорхой, нэг ажил, арга хэмжээний гүйцэтгэлийг 2000 тэмдэгтэд багтаах, тухайн ажлын гүйцэтгэл нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх, хүрээгүй бол түүний шалтгаан, нөхцөлийг заавал тодорхой дурдах гэсэн тусгай шаардлагуудыг заавал хангаж байх,
- Алба, хэлтсүүд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт хөрөнгө шийдвэрлэгдээгүйн улмаас удаашралтай, хэрэгжих нөхцөл бүрдээгүй арга хэмжээг Улс, нийслэлийн 2026 оны төсвийн төсөлд тусгуулах ажлыг зохион байгуулах арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

Албан бичиг, өргөдөл, гомдлын чиглэлээр:

- Иргэдээс нэг ижил утгатай, нэг иргэнээс дахин хандсан өргөдөл, гомдлыг холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд өргөдөл, гомдолд дурдсан асуудлыг бүх талаас нь нягтлан судалж, хууль зүйн үндэслэлтэй, нэг мөр, эцэслэн шийдвэрлэхэд анхаарах.
- Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам болон байгууллагаас баримтлах бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагаандаа иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтэд агуулагдсан санал, санаачилгыг тусгахад анхаарах,
- Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэхэд иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн үзүүлэлтийг харгалзан үзэх.
- Өргөдөл, гомдлын хариуг иргэнд цахимаар, утсаар, шуудангаар, биечлэн аль ч хэлбэрээр өгсөн байхаас үл хамаарч өргөдөл, гомдлын дэд системд шийдвэрлэлтийг дэлгэрэнгүй тэмдэглэж, холбогдох файлыг хавсаргана. ("Иргэдээс Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам"-ын 8.2 дахь хэсэг)
- Албан бичиг, өргөдөл, гомдлыг өдөрт нь багтаан хүлээн аваагүй, явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчил дийлэнх хувийг эзэлж байгаагаар холбогдуулан ERP, eDoc систем ашиглалтад нэгжийн дарга, ахлах мэргэжилтэн болон нийт албан хаагчид анхаарч ажиллах,
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхдээ системд явцын тэмдэглэл хөтлөх, хаалтын үйлдлийг гүйцэтгэхдээ иргэний овог, нэр, утасны дугаарыг тэмдэглэхгүй байхад анхаарч ажиллах шаардлагатай байна.

4.3. Байгууллагын ил тод, нээлттэй байдлын үнэлгээ.

Байгууллагын ил тод, нээлттэй байдлын 3 шалгуур үзүүлэлтийн хэсгийн дундаж **85,2** хувь буюу **"Бүрэн хангалттай"** гэж үнэлэгдсэн.

- Байгууллагын <https://uds.ub.gov.mn/> цахим хуудсанд хөгжүүлэлт хийх шаардлагатай байна. Тухайлбал: "Үндсэн веб" хуудсанд байршуулсан мэдээ, мэдээллийн загвар, дизайныг шинэчилж, хэрэглэгч, үйлчлүүлэгчдэд хэрэглэхэд ойлгомжтой, хялбар бүтэцтэй болгох, (Бусад байгууллагын цахим хуудастай харьцуулж, хөгжүүлэлтийг хийх.)
- Байгууллагын цахим хуудасны мэдээ, мэдээллийг Facebook page, YouTube channel, Twitter гэх мэт мэдээллийн олон сурвалж ашиглан, холбоос линк үүсгэн сошиалд хүргэх хүртээмжийг нэмэгдүүлэх талаар санаачилгатай ажиллах,
- Алба, хэлтсүүд өөрийн хариуцах асуудлын хүрээнд цахим хуудсанд байршуулсан мэдээ, мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд тухай бүр шинэчлэгдсэн мэдээллийг бүрэн байршуулж, тогтмол шинэчилж байх талаар анхаарах,
- Байгууллагын цахим хуудсаар дамжуулан төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар иргэд, олон нийтээс сэтгэл ханамжийн судалгааг авч, жил бүрийн үр дүнг харьцуулан дүгнэлт хийж, мэдээллийг ил тод, нээлттэй байршуулж ажиллах шаардлагатай байна.

ХЯНАСАН: ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



Д.ДАШЦЭЦЭГ

Л.АДЪЯАСҮРЭН